

БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ



2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 08 дугаар сарын 04-ний хооронд хийгдсэн ажлуудаас

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠲᠠᠯ ᠰᠤᠮᠤ ᠶ᠋ᠢᠨ 14 ᠬᠣᠨᠣᠭᠢᠶ᠋ᠢᠨ ᠴᠠᠭ ᠤᠡᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠲᠠᠯ ᠰᠤᠮᠤ ᠶ᠋ᠢᠨ 14 ᠬᠣᠨᠣᠭᠢᠶ᠋ᠢᠨ ᠴᠠᠭ ᠤᠡᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ



УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- 1. 2023 оны 07-р сарын 25 ны шөнө болсон хүчтэй дуу цахилгаантай аадар бороо, хүчтэй салхилсан байгалийн гамшигт үзэгдлийн улмаас сумын цахилгааны шугамд дараах асуудлууд үүссэн. Үүнд: 6/0,4кВ КТПН-61/ ктпн буюу Хувиарлах сүлжээ гэсэн үг/ -с 6/0,4кВ КТПН-62-руу гарсан Кабель шугам гэмтэж сумын төвийн хэрэглэгчид хүчдэлгүй болсон. Кабель шугамд төвөөс засварын бригад ирж мегометрээр хэмжилт хийж Кабель шугамын гэмтэл тодорхойлсон дараа нь 6/0,4кВ КТПН-66-с бэлтгэл буюу нөөц Кабель шугамаар сумын төвийн схем сэргээж хүчдэл залгасан.
- 2. Өнөөдрийн байдлаар засварын бригад Цагаандэлгэрийн агаарын шугамыг шинэчлэх ажлыг хийж байгаа тул манай суманд үүссэн гэмтэлтэй кабель шугамыг бүрэн засварлаж амжаагүй байна. Газар доогуурх далд шугамыг ухаж гаргах шаардлагатай байгаа. Одоогын байдлаар Сүлд Гэр хороололыг хүчдэлээр хангадаг КТПН-с нөөц тэжээлээр сумын төв буюу орон сууцуудыг хүчдэлээр ханган ажиллаж байна.





МОНГОЛЫН АЖ АХуйн, ХАВЧИЛГА, ХАМГААГАХ АЖ АХуйн ЯАМ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

2023 оны 07-д сарын 28-ны өдөр СГХУСАЗЗ-өөс засмал дагуу нутаглаж байгаа малчдаар орж зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малдаа зүүх гэрэлтдэг 50 ширхэг хүзүүвчийг жишиг байдлаар олголоо.





ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠲᠠᠯᠤ ᠭᠣᠪᠢᠰᠤᠮᠤᠪᠦᠷ

Орон нутаг хөгжил сан:



Сумын төвийн гэрэлтүүлгийн ажлыг Орон нутгийн Хөгжлийн Сангийн Хөрөнгөөр “Сүмбэр Солюшн” ХХК-аар хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Баянтал сумын 18-р зөрлөгийн оршин суугчдад зориулан Стандарт бие засах газрын ажлыг хийж дуусган хүлээлгэн өгөх хүсэлт ирүүлсэн.

Сургуулийн спорт урлаг заалны бие засах газрын засварын ажил гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна.



ᠪᠠᠶ᠋ᠠᠨ ᠲᠠᠯ
ᠭᠣᠪᠢ ᠰᠤᠮᠪᠦᠷ
ᠰᠤᠮᠤ ᠬᠣᠷᠰᠣᠭ
ᠬᠥᠭᠵᠢᠭᠦᠯᠡᠬᠦ
ᠰᠠᠩᠭᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР:

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН МЭДЭЭЛЭЛ

Сумын хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 2023 оны 07 дугаар сарын 30-ны байдлаар 42,928,024.00 / дөчин хоёр сая есөн зуун хорин найман мянга хорин дөрөв/ төгрөгийн орлого төвлөрсөн байна. Жилийн орлогын төлөвлөөний биелэлт 85,8%

Муу зээлийн эргэн төлөлт 13,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны зээлдэгч 1 /хэвийн/

2021 оны зээлдэгч 3 үүнээс /1 муу зээлдэгч/

2013-2019 оны 5 зээлдэгч / 5 муу зээлдэгч /

Дээрх муу зээлдэгч нарын өрийг ШШГГазартай хамтран барагдуулж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 17 дугаар тогтоолыг үндэслэн 06 дугаар сарын 01-ний өдрөөс 30 хоногийн хугацаанд ХХСангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл хүлээн авах зар түгээсэн боловч шаардлага хангасан төсөл ирээгүй, 2023 оны 08 дугаар сарын ИТХурлаар тов тогтоолгож дахин зарлана.



МОНГОЛ УЛАСНЫ
АЖ АХУЙН
ХААТ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах :

Нийт нутгаар бэлчээрийн гарц жигд байгаа бөгөөд Өвөрхангай аймгийн 852 мал бүхий 1 өрх оторлож байна. Мөн 2 малчин өрх Хэнтий, Төв аймгийн нутагт хадланд гарахаар техник засварын ажлаа эхлээд байна. Малчин өрхийн түвшинд бэлтгэх өвс тэжээлийн судалгааг гаргасан. Хонь ноослох ажил дууссан. Хүлэмжийн нарийн ногооны ургац хураалт эхлэн 2023.08.03-ны байдлаар 0.2 тн ургац хураан аваад байна.

Малын өвчний байдал, тайван эсэх:

Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.

Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ дамжуулж байгаа мэдээлэл:

Цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлийн мэдээллийг Баянтал ХААТ дундын групп, багуудын Засаг дарга нар болон багийн цахим хаягаар тухай бүр хүргэн ажиллаж байна.



МОНГОЛ УЛАСНЫ
АЖ АХУЙН
ХААТ



Улаан бурхан, улаанууд
урьдчилан сэргийлэх вакцинд 48
хүүхэд хамрагдсан байна.
Товлолт вакцинд 6 хүүхэд
хамрагдсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:



Улаан бурхан, улаанууд
урьдчилан сэргийлэх вакцинд 48
хүүхэд хамрагдсан байна.
Товлолт вакцинд 6 хүүхэд
хамрагдсан.

Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-105
 - Амбулаторийн үзлэг-74
Үүнээс:
 - Яаралтай түргэн тусламж - 21 хүн, Том хүн - 15, хүүхэд - 6
 - Идэвхитэй хяналт - 2 хүн
 - Өдрийн эмчилгээ - 0хүн
 - Хэвтэн эмчлүүлсэн - 8 хүн
 - Өдрийн эмчилгээ - 0
- Улаан бурхан, улаанууд
урьдчилан сэргийлэх вакцинд 48
хүүхэд хамрагдсан байна.
Товлолт вакцинд 6 хүүхэд
хамрагдсан.

Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага - 15
- Алсын дуудлага - 3
- Төвийн дуудлага - 12
- Том хүн - 13
- Хүүхэд - 2
- Осол гэмтэл - 0

Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт - 8
- Дотор - 7
- Хүүхэд - 1
- Халдварт - 0

Лабораторийн үзлэгийн тоо: 12 /давхардсан тоо/

- Цусны ерөнхий шинжилгээ
- Биохимийн шинжилгээ
- Шээсний шинжилгээ

ᠮᠡᠳᠡᠨᠢ ᠡᠬᠢᠶ᠎ᠠ ᠪᠡᠯᠲᠦᠭᠦᠰᠢᠨ ᠵᠳᠲᠦᠭᠰᠢᠷᠢᠨ ᠳᠠᠷᠭᠠ ᠴᠡᠯᠬᠠᠭᠪᠠᠳᠣᠨᠢᠳ



МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАДОНИД

ᠮᠡᠳᠡᠨᠢ ᠡᠬᠢᠶ᠎ᠠ ᠪᠡᠯᠲᠦᠭᠦᠰᠢᠨ ᠵᠳᠲᠦᠭᠰᠢᠷᠢᠨ ᠳᠠᠷᠭᠠ ᠴᠡᠯᠬᠠᠭᠪᠠᠳᠣᠨᠢᠳ